

**Цэнхэрмандал, Зүлэгтэй, Даланжаргалан, Луус
дэд станцуудын микропроцессорын реле хамгаалалтын
материал нийлүүлэх
тендерийн баримт бичиг**

Тендер шалгаруулалтын дугаар: ХАН№19/38

“БЗӨБЦТС” ТӨХК 2019 он

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: *Цэнхэрмандал, Зүлэгтэй, Даланжаргалан, Луус
дэд станцуудын микропроцессорын реле хамгаалалтын
материал нийлүүлэх тендерийн баримт бичиг*

Тендер шалгаруулалтын дугаар: ХА №19/38

Хаяг: Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС”
ТӨХК-ийн конторын байр.

Утас: 99022755, 99990883
Факс: 70210167

ХА№19/38 тоот тендерийн урилга

Цэнхэрмандал, Зүлэгтэй, Даланжаргалан, Луус дэд станцуудын микропроцессорын реле хамгаалалтын материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг урьж байна.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. /Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрч авна уу/

Хаяг : Улаанбаатар хот Багануур дүүрэг үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ний конторын байр 202 тоот өрөө.

Утас: 99022755. 99990383

Факс: 70210167

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---|------|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан цахим хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал.
(б) Нийлүүлэлтийн хуваарь.
(в) Техникийн тодорхойлолт.
(г) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материал. /ТШӨХ-ийн ТООЗ 1.1-д заасны дагуу/ |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Хоёр. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар нотариатаар баталгаажуулж ирүүлэх 2. Үнийн санал /маягтын дагуу/ 3. НӨАТ төлөгч бол гэрчилгээний хуулбар , НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан тоот ирүүлэх 4. 2017-2018 оны аудитлагдсан санхүүгийн тайланг, аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх. 5. Сүүлийн хоёр жилийн нийт борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. / үнэлгээнд www.tender.gov.mn цахим сайтын лавлагааг үндэслэнэ/ 6. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх шүүхийн төрөлжсөн архив, ШШГЕГ-ын тодорхойлолтыг тус тус ирүүлэх 7. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх /татварын тодорхойлолтыг үнэлгээнд www.tender.gov.mn цахим сайтын лавлагааг үндэслэнэ./ 8. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолт ирүүлэх ./Захиалагчаас өгсөн техникийн шаардлага хангасан байх/ 9. Тендерийн баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны цахим хаягаар ирүүлэх. 10. Нийлүүлэгч ГТН 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. 11. Нийлүүлэх хугацаа 45 хоногоос ихгүй , хүргэх газар Багануур дүүргийн үйлдвэрийн хэсгийн “БЗӨБЦТС” ТӨХК-ийн агуулахад . 12. Сүүлийн 3 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт гэрээ, гэрээ дүгнэсэн акт тэдгээрийн ажлын өртөг, хугацаа байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт ирүүлэх. 13. Одоо хэрэгжүүлж буй бараа материал нийлүүлж байгаа гэрээний жагсаалтыг маягтын дагуу ирүүлэх. 14. Бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө төлбөрийг оролцуулахгүйгээр гэрээг хэрэгжүүлэх чадвартай байх. 15. Өмнөх онуудад хийгдэж байсан гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан нь тендерээс татгалзах үндэслэл болно. <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1.3 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТӨӨЗ 2.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: УБ хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн өөрийн байр, 2-р давхар 202 тоот өрөө 99022755, 99990883
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг: Энэхүү бараа материал нийлүүлэх тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn цахим хаягаар тендерийн баримт бичгийг авна. Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2019 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн 15 цаг 00 минутад.
ТӨӨЗ 2.2	Тендерийн нээлт хийх хугацаа нь: 2019 оны 04 дугаар сарын 10 ний өдрийн 15 цаг 30 минутад цахим системээр нээнэ.
ТӨӨЗ 7.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр дугаар бүхий байна: ХАН№19/38 “Цэнхэрмандал, Зүлэгтэй, Даланжаргалан, Луус дэд станцуудын микропроцессорын реле хамгаалалтын материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг” Багцтай эсэх: Үгүй

дугаар	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Техникийн үзүүлэлт
1	Хүчний трансформаторын хамгаалалт	ш	2	техникийн тодорхойлолтын дагуу
2	Цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалт	ш	9	техникийн тодорхойлолтын дагуу

БАРАА МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Нийлүүлэгчийн санал болгосон бараа нийлүүлэх хугацаа	
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа
1	2	3	4	5	6	7

ОДОО ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БАРАА МАТЕРИАЛЫН ГЭРЭЭ

Тендерт оролцогч одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаар хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ХАМГААЛАЛТЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛТ

Реле нь дараах техникийн үзүүлэлт, шаардлагуудыг хангасан байх ба Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг стандартын шаардлагууд, Олон улсын IEC стандартын нөхцөл шаардлагад бүрэн нийцсэн, загварын хувьд ашиглагдан туршигдсан, шинэ реле байх ёстой. Ашиглалтын заавар Монгол, Англи хэлээр байх.

д/д	Үзүүлэлт	Функцин төрөл
1	Хамгаалалтын функц	<ul style="list-style-type: none"> - Фазын гүйдлийн ихсэлтийн хугацаагүй хамгаалалт - Газардлагын ихсэх гүйдлийн хугацаагүй хамгаалалт - Нойлийн ихсэх гүйдлийн хугацаагүй хамгаалалт - Тэг дараалалын ихсэх гүйдлийн хамгаалалт - Ихсэх гүйдлийн хугацаатай хамгаалалт - Газардлагын ихсэх гүйдлийн хугацаагүй хамгаалалт - Нойлийн ихсэх гүйдлийн хугацаатай хамгаалалт - Тэг дараалалын ихсэх гүйдлийн хугацаатай хамгаалалт - Давтамжийн ихсэлт бууралт - Таслуур татгалзалтын хамгаалалт - Автоматаар дахин залгалтын хяналт - Хүчдэлийн хамгаалалт <ul style="list-style-type: none"> а. Хүчдэлийн бууралт б. Хүчдэлийн ихсэлт в. Чадал мэдрэх г. Хүчдэлийн хяналт - Нумын хамгаалалтын оролтуудтай - Оролт нь хувьсах тогтмол 220В-д ажиллах
2	Сүлжээний холболт болон хяналт	<ul style="list-style-type: none"> - EIA-232, EIA-485 шилэн кабелийн “Ethernet” сүлжээ болон шилэн кабелийн EIA-232 портуудтай - IRIG-B “time code” оролттой - Modbus RTU slave, Modbus TCP/IP, Ethernet FTP, Telnet, Mirrored bits, IEC 61850, Device Net болон файл дамжуулах протоколуудтай - Аваарийн үеийн бичигчтэй мэдээлэл түргэн дамжуулах протоколуудтай
3	Ажиллах чадвар	<ul style="list-style-type: none"> - Реле нь ажиллах хүчдэл 85-264 VAC, 85-275 VDC - Ажиллах температур -40 –өөс +85°C - Компьютерийн болон бусад бүх оролтууд хэт хүчдэлийн цэнэг шавхалтын хамгаалалттай - Хүчдэл тасрахад 0.8 сек өөрийнхөө тэжээлийг барих чадвартай - Аваарийн үеийн бичлэг надваржилт өндөртэй санах ойд бичигдэнэ - Хүчтэй доргилтод тэсвэртэй
4	Гүйдлийн оролт:	<ul style="list-style-type: none"> - Хэвийн үед 5А - Байнгын үргэлжлэх 15А - Хамгийн их гүйдэл 500А (1сек), 1250А (1 бүтэн үед)

ХҮЧНИЙ ТРАНСФОРМАТОРЫН ХАМГААЛАЛТЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛТ

Реле нь дараах техникийн үзүүлэлт, шаардлагуудыг хангасан байх ба Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг стандартын шаардлагууд, Олон улсын IEC стандартын нөхцөл шаардлагад бүрэн нийцсэн, загварын хувьд ашиглагдан туршигдсан, шинэ реле байх ёстой. Ашиглалтын заавар Монгол, Англи хэлээр байх

д/д	Үзүүлэлт	Функцын төрөл
1	Үндсэн функц	<ul style="list-style-type: none"> - Таслуурын хамгаалалт - Трансформаторын ялгаварт гүйдэл
2	Нэмэлт функц	<ul style="list-style-type: none"> - Ачааллаас хамаарч давтамж уналт - Ачааллаас хамаарч хүчдэлийн уналт
3	Хамгаалалтын хэсэг	<ul style="list-style-type: none"> - Ихсэлтийн функц /нэгж давтамж дахь хүчдэлийн/ - Хүчдэл бууралтын - Чадлын элемент - Газардлагын гүйдлийн ихсэлт - Фазын гүйдлийн ихсэлт - Эсрэг дарааллын - Газардуулгын хугацаатай гүйдлийн ихсэлт - Фазын хугацаатай хамгаалалт - Эсрэг дарааллын хугацаатай гүйдлийн ихсэлт - Хүчдэлийн ихсэлт - Давтамжийн багасалт /давтамжийн ихсэлт/ - Ялгаварт гүйдлийн - Оролт нь хувьсах тогтмол 220В-д ажиллах
4	Холболтын оролтуудад	<ul style="list-style-type: none"> - 2ш гурван фазын гүйдлийн ороомгийн оролт - 1 фазын газардуулгын эсэргүүцлийн оролт - 3 Фазын хүчдэлийн оролт - EIA-232, EIA-485 шилэн кабелийн “Ethernet” сүлжээ болон шилэн кабелийн EIA-232 портуудтай
5	Ажиллах чадвар	<ul style="list-style-type: none"> - Реле нь ажиллах хүчдэл: 85-350VDC, 85-264 VAC - Хүчдэл тасралтанд 2 сек өөрийнхөө тэжээлийг барих чадвартай - Доргилтод тэсвэртэй
6	Гүйдлийн оролт	<ul style="list-style-type: none"> - Хэвийн үед 5А - Байнгын үргэлжлэх 15А - Хамгийн их гүйдэл 500А (1сек) - 1250А (1 бүтэн үед)

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019 оны дүгээр сарын-ны өдөр

БЗӨБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>1</i> жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Нийлүүлэхээр санал болгож буй материалыг эрх бүхий байгууллагаар туршилт тохируулга хийлгэж протоколын хамт ирүүлэх.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ 9.1. Алданги оногдуулах хувь: **Гэрээний дүнгийн нэг хоногийн 0,5%**
- Алдангийн нийт дүн: **Гэрээний дүнгийн 10%**

